



Хяналт шалгалт, зохицуулалтын газар

2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	4
1.1.2 Даатгалын зах зээл	6
1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага	9
1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо.....	11
1.1.5 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа.....	12
1.1.6 Бусад.....	13

ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Нийт өргөдөл, гомдлын тоо (салбараар)	2
Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга.....	4
Хүснэгт 3. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга.....	6
Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл	8
Хүснэгт 5. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга.....	9
Хүснэгт 6. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга	11
Хүснэгт 7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга.....	12
Хүснэгт 8. Бусад.....	13

ГРАФИК

График 1. Өргөдөл, гомдлын салбарын харьцуулалт.....	3
График 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт.....	5
График 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн хэлбэр.....	5
График 4. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт.....	7
График 5. Даатгалтай холбоотой өргөдлийн хэлбэр.....	7
График 6. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт.....	10
График 7. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн хэлбэр.....	10
График 8. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт.....	11

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо мөн хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэх хүрээнд хэрэгжүүлэн ажилладаг.

Дээрх чиг үүргийн дагуу хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан, гомдлыг барагдуулах талаар санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх (1), зохих маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлүүлэх (2), хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (3), хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийг төлөөлж хууль, шүүхийн байгууллагад хандах, тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах (4), эрх ашиг нь зөрчигдсөн хөрөнгө оруулагчдын хохирлыг барагдуулах талаар хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авч ажиллах (5) зэрэг арга хэмжээг тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар хариуцан гүйцэтгэж байна.

Хяналт шалгалт, зохицуулалтын газар 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 318 өргөдөл, гомдол хүлээн авснаас албан бичгээр хандсан 226, цахим системээр хандсан 81, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 11 өргөдөл, гомдол байна.

Тайлант хугацаанд 299 өргөдөл, гомдлын хуулийн хугацаанд хянаж шийдвэрлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан бол 19 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.


Нийт ирүүлсэн (бичгээр, цахим системээр, 11-11 төвөөр дамжуулан) өргөдөл, гомдлын тоо дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Нийт өргөдөл гомдлын тоо (салбараар)

№	Салбар	2023.I	2024.I	2025.I				
				Албан бичиг	Info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Даатгал	115	108	86	56	4	146	46.0%
2	Үнэт цаас	56	44	45	2	3	50	16.0%
3	ББСБ	52	46	46	18	1	65	20.0%
4	ХЗХ	8	10	16	-	-	16	5.0%
5	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа	-	-	15	2	-	17	5.0%
6	ВХҮҮ	-	-	-	2	3	5	2.0%
7	Бусад	47	10	18	1	-	19	6.0%
Нийт		278	218	226	81	11	318	100%

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын 46% хувийг даатгалын үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.

График 1.Өргөдөл, гомдлын салбарын харьцуулалт



Шийдвэрлэлтийн явц, авах арга хэмжээний хүрээний ялгаатай байдлаас хамааран тухайн өргөдөл, гомдлыг хянан, шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байгаа бөгөөд нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 21 хоног байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаанд Хороонд ирж буй дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулга нь тухайн салбар бүрийн мэргэжлийн онцлогоос хамааран ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй байдаг нь нөлөөлж буйгаас гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдөлд эрх бүхий албан тушаалтны зүгээс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, прокурорын байгууллагаар хянуулах шаардлага үүсдэгтэй холбоотой.

1.1 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1 болон холбогдох бусад хууль тогтоомжийн зүйл, заалтад тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор үзүүлэв.

2025 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын судалгааны тайлан

1.1.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой нийт 50 өргөдөл, гомдол ирүүлснээс бүрэн шийдвэрлэсэн байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.I	Эзлэх хувь	2024.I	Эзлэх хувь	2025.I				
						Албан бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	22	39.2%	8	18.1%	6	-	-	6	12.0%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээллийг шалгуулах	12	21.4%	8	18.1%	2	-	1	3	6.0%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	-	-	-	-	-	-	0.0%
4	ХОЭБ	1	2.0%	-	-	1	-	-	1	2.0%
5	Хамтын сан	-	-	-	-	-	-	-	-	0.0%
6	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	3	5.3%	1	2.2%	2	2	-	2	8.0%
7	Тохиромжтой этгээдийн тодорхойлолт	-	-	9	20.0%	10	-	-	10	20.0%
8	Үнэт цаасны харилцагчийн эрх ашиг хөндөгдсөн талаар	-	-	3	6.8%	20	-	-	20	40.0%
9	Ногдол ашиг тараах	-	-	-	-	1	-	2	3	6.0%
10	УЕПГ-ын хяналт дор холбогдох цагдаагийн хэлтэс рүү шилжүүлэх	-	-	8	18.7%	-	-	-	-	0.0%
11	Ноглох баримт гаргах	-	-	-	-	1	-	-	1	2.0%
12	Зөрчилтэй холбоотой	-	-	-	-	-	-	-	-	0.0%
13	ХОС	-	-	6	13.6%	-	-	-	-	0.0%
14	Бусад	18	32.1%	1	2.2%	2	-	-	2	4.0%
Нийт		56	100%	44	100%	45	2	3	50	100%

График 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт





График 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн хэлбэр



Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “ҮЦГХТ” ХХК, үнэт цаасны компаниудаас баримт, тайлбар гаргуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд үнэт цаастай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлуудаас хувьцааны бүртгэл данс шалгуулах тухай 6 хувь, хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсан 12 хувь, ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой 8 хувийг тус тус эзэлж байна. Энэ төрлийн өргөдлийн тоо өссөн шалтгаан нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ягаан цэнхэр тасалбартай холбоотой мэдээллийг

2025 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын судалгааны тайлан

шалгуулах, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд харилцагчдын их хэмжээний мөнгө тараагдаагүй төвлөрч байна гэх мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс өмнө нь тухайн асуудлаар хандан Хорооноос албан бичгээр хариу өгсөн асуудлаар дахин хандах тохиолдлууд нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр хувьцаа арилжсантай холбоотой өргөдөл, гомдлоос хувьцаа худалдах, захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөл, мөнгө олгосон тайланд нэр бүхий иргэний гарын үсэг зурагдсан гэх утгатай өргөдөл, гомдол багагүй хувийг эзэлдэг бөгөөд гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийн хуурамч эсэхийг холбогдох эрх бүхий байгууллагаар тогтоолгох талаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Мөн 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн холбогдох этгээд, тэдгээрийн талаарх бүртгэл, мэдээлэл байхгүй байгаа талаар, ХК-аас ногдол ашиг олгохгүй байгаа болон татан буугдсан брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогддоггүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар хуулийн байгууллагад хандуулахаар урьдчилсан шийдвэр гаргасан тохиолдлууд багагүй хувийг эзэлж байна.

1.1.2 Даатгалын зах зээл

Тайлант хугацаанд даатгалын үйлчилгээтэй холбоотой бичгээр ирүүлсэн нийт 146 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 130 өргөдлийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, 16 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 3. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.I	2024.I	2025.I				
				Албан бичиг	Цахим, Info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	45	71	59	24	-	83	57.0%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	48	19	12	18	1	31	21.0%
3	Нөхөн төлбөрийг хасч лгосон	10	8	4	1	-	5	3.0%
4	Даатгалын хураамжийн маргаан	1	3	2	-	-	2	1.0%
5	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	11	5	8	13	3	24	16.0%
6	Даатгалын үйл ажиллагаа	-	2	1	-	-	1	1.0%
Нийт		115	108	86	56	4	146	100%

График 4. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн харьцуулалт





График 5. Даатгалтай холбоотой өргөдлийн хэлбэр



2025 оны I дүгээр улирлын өргөдөл, гомдлын судалгааны тайлан

Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

№	Даатгалын төрөл	2023.I	Эзлэх хувь	2024.I	Эзлэх хувь	2025.I				
						Албан бичиг	Цахим, info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	61	50.4%	26	24.0%	6	4	-	10	7.0%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	35	31.3%	64	59.2%	65	48	1	114	78.0%
3	Гэнэтийн ослын даатгал	7	6.0%	8	7.4%	2	1	-	3	2.0%
4	Хөрөнгийн даатгал (ипо тек)	4	3.4%	5	4.7%	5	2	-	7	5.0%
5	Хариуцлагын даатгал	-	-	1	1.0%	1	-	-	1	1.0%
6	Зээлийн даатгал	-	-	-	-	1	-	-	1	1.0%
7	Санхүүгийн даатгал	-	-	-	-	-	-	-	-	0.0%
8	Ачааны даатгал	2	1.7%	-	-	1	-	-	1	1.0%
9	Гэрлэлтийн даатгал	-	-	1	1.0%	2	-	-	2	1.0%
10	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	6	6.0%	3	2.7%	3	1	3	7	5.0%
Нийт		115	100%	108	100%	86	56	4	146	100%

Ирсэн өргөдөл, гомдлын агуулгаас үзэхэд, даатгуулагч даатгалын тохиолдол гарсан үед тухайн тохиолдлыг нотлох, даатгагч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг үүргээ биелүүлээгүй, даатгалын хураамжийг хуваарьт заасан хугацаанд нь төлөөгүй зэргээс үүдэн даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүсдэг байна.

2025 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын судалгааны тайлан

Мөн даатгагчийн зүгээс иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг байдлыг ашиглан үндэслэлгүйгээр нөхөн төлбөрийг хасаж олгосон, даатгалын нөхөн төлбөр олгохдоо хууль тогтоомж болон гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавих, бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахдаа даатгуулагчид бүтээгдэхүүний талаар танилцуулга хийгээгүй, зөвшөөрөл авалгүйгээр гэрээ хийх, гэрээнд заасан эрсдэлийн дагуу даатгалын тохиолдолд үүсэж, гэрээнд нөхөн төлбөр олгохоор зохицуулагдсан байхад илт үндэслэлгүйгээр татгалзах, нөхөн төлбөр олгохгүй удаах, даатгуулагчдыг чирэгдүүлж, даатгалын гэрээнд даатгалын зүйлийн талаарх мэдээллийг зөрүүлж бичсэн зэрэг зөрчил дутагдал гаргасан байна.

Тайлант хугацаанд харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан 58 иргэн, хуулийн этгээдэд 1,348,816,530 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 35 иргэн, хуулийн этгээдэд 682,149,545 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 65 өргөдөл, гомдол ирүүлснээс 64 өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн бол 1 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 5. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.I	Эзлэх хувь	2024.I	Эзлэх хувь	2025.I				
						Албан бичиг	Цахим, (info)	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	12	23.0%	25	64.1%	17	9	-	26	40.0%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	3	5.7%	2	5.2%	4	-	1	5	8.0%
3	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	1	1.9%	1	2.6%	3	2	-	5	8.0%
4	Зээлийн гэрээний маргаан	-	-	6	15.3%	1	-	-	1	2.0%
5	ББСБ-ын үйл ажиллагаа	18	34.6%	3	7.7%	11	5	-	16	25.0%
6	Лавлагаа	8	15.3%	-	-	6	-	-	6	9.0%
7	Бусад	10	19.2%	2	5.1%	4	2	-	6	9.0%
Нийт		52	100%	39	100%	46	18	1	65	100%

Ирүүлсэн өргөдөл, гомдлын 40 хувийг зээлийн мэдээллийн сантай холбоотой, 2 хувийг зээлийн гэрээний маргаантай холбоотой, 25 хувийг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тус тус эзэлж байна.

График 6. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт





График 7. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн хэлбэр



Ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувийг зээлийн мэдээллийн сантай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.

Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой гомдлын хувьд иргэд зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, өөрсдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас зээл хойшлуулах хүсэлтээ

2025 оны I дүгээр улирлын өргөдөл, гомдлын судалгааны тайлан

тухайн банк бус санхүүгийн байгууллагад албан ёсоор хүргүүлээгүйн улмаас маргаан үүсэх, улмаар зээлийн мэдээллийн сан дахь зээлийн ангилал буурч бүртгэгдэх тохиолдлууд гарсаар байна. Мөн дээрх байдал нь иргэдийн авсан зээлийн чанар муудахад нөлөөлсөн байна.


1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан нийт 16 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 6. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.I	Эзлэх хувь	2024.I	Эзлэх хувь	2025.I				
						Албан бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Лавлагаа гаргуулах	1	12.5%	6	60.0%	11	-	-	11	69.0%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	-	-	-	-	-	-	0.0%
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	3	37.5%	2	20.0%	4	-	-	4	25.0%
4	Бусад	4	50.0%	2	20.0%	1	-	-	1	6.0%
Нийт		8	100%	10	100%	16	-	-	16	100%

График 8. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн харьцуулалт



1.1.5 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулиар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд Санхүүгийн зохицуулах хороонд иргэдээс ирүүлсэн хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, шийдвэрлэн, арга хэмжээг авч ажиллаж байна.

Тайлант хугацаанд мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдуулан нийт 17 өргөдөл, гомдол ирүүлснээс 17 өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.I	Эзлэх хувь	2024.I	Эзлэх хувь	2025.I				
						Албан бичиг	Цахим	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Өндөр хүүтэй зээл олгох	-	-	3	100%	3	-	-	3	18.0%
2	Алданги, хүү буруу тооцох	-	-	-	-	2	-	-	2	12.0%
3	Зээлийн барьцааг борлуулах	-	-	-	-	2	1	-	3	18.0%
5	Зээлийн эргэн төлөлт шалгуулах	-	-	-	-	1	-	-	1	6.0%
6	Цахим хаягаар өндөр хүүтэй зээл олгох	-	-	-	-	0	-	-	-	0.0%
7	Барьцааг эргүүлэн өгөхгүй байх	-	-	-	-	2	-	-	2	12.0%
Нийт		-	-	3	100%	15	2	0	17	100%

1.1.6. Бусад

Хүснэгт 8. Бусад өргөдлийн товч утга

№	Төрөл	2025.I			
		Албан бичгээр	Цахим	11-11 төв	Нийт
1	Хорооны хяналттай холбоотой	1	-	-	1
2	Зөрчлийн болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой	8	-	-	8
3	Лавлагаа, хүсэлт, хуулбар гаргуулах	9	1	-	10
Нийт		18	1	-	19

ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АРГА ХЭМЖЭЭ

1. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр цахим мэдээллийн хэрэгслээр явж буй зар сурталчилгаанд хяналт тавих чиг үүргийн дагуу цахим хуудсуудаар гарч буй мэдээлэлтэй танилцаж, зөрчил гаргасан байж болзошгүй болон зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдтэй холбогдуулан хууль тогтоомжийн дагуу тухай бүр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч болон бусад шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй иргэдэд зориулж Хорооны албан ёсны цахим хаяг (инфо/info@frc.mn)-аар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэж байна.
3. Ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын бүртгэлийг зохицуулалтын салбар тус бүрээр тогтмол хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

--o0o--